

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, АҮЭБЯ-ны стратеги төлөвлөгөө (2025-2028)	Төсөв /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл ийн хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
Зорилго 1. Боловсруулах аж үйлдвэрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2028 онд 4.9 хувьд хүргэнэ.								
Зорилт 1. Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого, стратегийг тодорхойлж, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлагаар хангах.								
1.1	Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлогыг боловсруулах, төлөвлөх, үйл ажиллагааны чиглэл, стратегийг тодорхойлох, холбогдох байгууллагаар батлуулах.	Улсын төсөв	Батлагдсан баримт бичгийн тоо	0	2	-	- "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" болон УИХ-ын 2025.05.29-ны өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-д "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн парк зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулна"-аар санал өгч тусгуулсан. - Аж үйлдвэржилтийн үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлсэн. 2025.02.13	100
1.2	Аж үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, норм норматив, стандарт, аргачлал, маягт, төсөл хөтөлбөр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулна.	Улсын төсөв	Боловсруулсан төслийн тоо	0	1	1	- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д заасны дагуу "Үйлдвэрлэл технологийн паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт"-ыг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Жагсаалт	100

							батлах тухай” 204 дүгээр тогтоолоор батлуулсан. - Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Бүтээн байгуулалтын төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 185 дугаар “тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2024 оны 03 сарын 26-ны өдрийн 154 дүгээр тогтоолыг батлуулсан. - Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.3-д Засгийн газар төрийн өмчийн паркийн удирдлагыг байгуулах, дүрмийг батлахаар заасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 257 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, Эрдэнэс ҮТП ХХК-ийн дүрмийн төслийн боловсруулан 2025.04.10-ний өдөр ЗГХЭГ-т хүргүүлсэн. - Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тухай журмын төслийг боловсруулж 2025.01.17-ны өдөр АҮЭБ-ийн сайдын зөвлөх болон АҮБГ-ын даргад танилцуулж өгсөн санал, зөвлөмж, чиглэлийн дагуу “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, хяналт тавих журмын төсөл”-ийг боловсруулах үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж, ТНБД-аар батлуулан 2025.02.10-ны өдөр СХОГ-т хүргүүлсэн. - “Хараат бус судалгааны Арвис төв” ТББ-ын гүйцэтгэх захирлаас “Дундын тайлан хүргүүлэх тухай” 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01/09 дугаартай албан бичгээр “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих харилцааг нарийвчлан зохицуулсан эрх зүйн баримт бичиг боловсруулах үйлчилгээний тайлан”-г ирүүлсэнтэй танилцаж, хариуг АҮБГ-ын даргын 2025.06.24-ны өдрийн 03/1883 дугаар албан бичгээр хүргүүлж, ирүүлсэн	
--	--	--	--	--	--	--	--	--

							эцсийн тайланг хүлээн авах актыг баталгаажуулж, холбогдох газарт хүргүүлсэн. - “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тухай журам” болон “Паркийн нэгжээс паркийн удирдлагад төлөх хураамжийн хэмжээ, төлөх журам”-ын төслийг тус тус боловсруулан, Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу санал авахаар АҮЭБЯ-ны цахим хуудсанд 2025.07.01-ний өдөр байршуулж, журмын төсөлд санал авах тухай АҮБГ-ын даргын 2025.07.04-ны өдрийн 03/1990 дугаартай албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн, саналыг авч нэгтгэн ажилласан. - Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандарт зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах зөвлөмжийн дагуу MNS 7085:2025, MNS7084:2025, MNS 7082:2025, MNS 7083:2025 Стандартуудыг боловсруулж Байгаль орчны стандартчиллын техникийн хорооны хуралд 2025.10.13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, СХЗГ-ын даргын 2025.11.05-ний өдрийн С/34 дүгээр тушаалаар дээрх стандартуудыг батлуулсан.	
1.3	Аж үйлдвэрийн салбарын төслүүдэд бодлогын дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүй, нэгдсэн удирдлагаар хангана.	Улсын төсөв	Шийдвэрийн тоо	0	1	1	- Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд саналыг ЭЗХЯ-д хүргүүлсэн. (2025.01.09 № 01/44) - Бүтээн байгуулалтын төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2024 оны 185 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Зэс боловсруулах цогцолбор” ХХК-ийн орон тоо, төсвийн саналыг АҮЭБЯ-ны	100

							ТНБД-ын 2024.12.23-ны өдрийн 03/1397 дугаар албан бичгээр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ш.Мөнхцэрэнд хүргүүлсэн. - Засгийн газрын 2024 оны 185 дугаар тогтоолоор байгуулагдсан Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг хариуцан хэрэгжүүлэх "Зэс боловсруулах цогцолбор" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийг тогтоох зорилгоор Засгийн газрын 2025 оны 154 дүгээр тогтоолыг батлуулж, Засгийн газрын 2024 оны 185 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулсан. - Засгийн газрын 2024 оны 185 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компанийн охин компани хэлбэрээр байгуулагдсан “Зэс боловсруулах цогцолбор” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Өлзийбаяраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлж өгөх хүсэлтийг АҮЭБ-ийн сайдын 2025.09.16-ны өдрийн 01-2649 дугаар албан бичгээр МУ-ын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн. - Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Зэс боловсруулах цогцолбор, Гангийн цогцолбор, Газрын тос боловсруулах үйлдвэр” зэрэг мега төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийн төслийг боловсруулан АҮЭБ-ын сайдын 2025.07.25-ны өдрийн 01/2112 дугаар албан бичгээр ЗГХЭГ-ын даргад хүргүүлж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025.08.13-ны өдрийн 60 дугаар захирамжаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах ажлын	
--	--	--	--	--	--	--	--	--

							даалгавар, техник, эдий засгийн үндэслэлийн тодотголыг батлуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулан байгуулаад байна. - Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас боловсруулж ирүүлсэн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын техникийн даалгавар”-ыг холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т хүргүүлсэн. - Үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах “Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр”, “Кабель утас үйлдвэрлэх үйлдвэр”, Тавантолгойн ордыг түшиглэн барих Кокс-эрчим хүчний үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хэлэлцэн хүлээн авсан. - “Вестерн Холд” ХХК-д Ховд аймгийн Буянт, Дарви сумын нутаг дэвсгэрт “Ховд” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх “Тусгай зөвшөөрөл олгох” тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулж, АҮЭБ-ийн сайдын 2025.09.16-ны өдрийн 01/2656 дугаар албан бичгээр яамдаас санал авч нэгтгэх ажлыг зохион байгуулсан. Гэвч Сангийн яамнаас “Вестерн Холд” ХХК-тай байгуулсан гурван талт гэрээгээр “Албан татвар төлөх хугацааг хоёр жил хүртэл хугацаагаар буюу 2027 он хүртэл сунгасан тул ижил төрлийн дэмжлэгийг давхардуулан үзүүлэх сөрөг үр дагавартай байх тул “Тусгай зөвшөөрөл олгох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг дэмжих боломжгүй гэсэн хариуг 2025.10.23-ны өдрийн 01/9594 дүгээр албан бичгээр ирүүлсэн. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлын хүрээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу	
--	--	--	--	--	--	--	--	--

							баримт бичгийн бүрдэл хангасан “Эрдэнэс ҮТП” ХХК-д Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт “Бор-Өндөр” ҮТП, Сэлэнгэ аймгийн Сайхан, Орхон сумын нутаг дэвсгэрт “Хөтөл” ҮТП, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт “Тавантолгой” ҮТП-ийн үйл ажиллагаа эрхлэх “Тусгай зөвшөөрөл олгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулж, АҮЭБ-ийн сайдын 2025.08.18-ны өдрийн 01/2337 дугаар албан бичгээр бүх яамдаас санал авч нэгтгэсэн. Холбогдох материалыг АҮЭБ-ийн сайдын 2025.09.18-ны өдрийн 01/2692 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	
1.4	"Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлж, бодлогын нэгдсэн удирдлагаар хангана.	876,866.5	ТЭЗҮ тодотгол, ТТҮ, зураг төсөл боловсруулж, батлуулах, үйлдвэрийн барилга, байгууламж барих ажлын гүйцэтгэл, хувиар	5	10	55	- "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлж ажлын хүрээнд дараах ажил гүйцэтгэсэн. Үүнд: - Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж 2022 оны СТР-2022-01 дүгнэлт гарсан. - АҮЭБЯ-ны Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн 2025.03.31-ний өдрийн хурлаар ТЭЗҮ-ийн тодотголыг хэлэлцэж буцаасан. ТЭЗҮ-г 2025.08.12-ны хуралдаанаар дахин хэлэлцэж хүлээн авсан. - Техник, технологийн түвшний үнэлгээг АҮЭБЯ-зөвлөлөөр хэлэлцүүлэх хурлын товд оруулсан. - Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ батлагдсан. - Засгийн газрын 2024 оны 185 дугаар тогтоолоор тус төслийг хариуцсан хэрэгжүүлэх “Зэс боловсруулах цогцолбор” ХХК-ийн байгуулж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2025.01.31-ний 09-р тогтоолоор Эрдэнэт	100

							үйлдвэр ТӨҮГ-ийн бүтцэд байгаа Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгжийн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих чиг үүрэг, орон тоо, дэд бүтцийг холбогдох баримт бичгийг “Зэс боловсруулах цогцолбор” ХХК-д шилжүүлэхээр шийдвэрлэсэн.	
1.5	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барихад бодлогын дэмжлэг үзүүлнэ.	73,923.8	Дэд бүтцийн ажлын явц, хувь	40	45	50	Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийгнажлын явц: - Авто замын гэрэлтүүлэг барих ажлын явц-30%, авто зам /12.7 км, 4.2 сая ам.доллар/ барьж байгуулах ажлын гүйцэтгэл-60%, Төмөр зам /1-р ээлж 4.4 км, 4.5 сая. ам доллар/ барьж байгуулах ажлын гүйцэтгэл-100%. Улсын комисс ажилласан. Төмөр замын 2-р ээлжийн ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг эхлүүлсэн. Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын явц 100%. - Цахилгаан хангамжийн ТЭЗҮ боловсруулах ажлыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 3 багц тендер болгон зарласан. • Багц-1 буюу “220/110/35 кВ-ын 2х200 МВА чадалтай “Оюут” дэд станцыг барих ажил”-ын гүйцэтгэгчээр “Саруул өргөө констракшн” ХХК шалгарч, 2025.05.19-ны өдөр гэрээ байгуулж, дэд станцын барилгын ажил нарийвчилсан төлөвлөгөөний дагуу эхэлсэн ба газар шорооны ажил дууссан, Бетон цутгалт, суурийн ажлууд 90% хүрсэн, бараа материалын захиалга бүрэн хийгдсэн. Нийт ажлын явц 50% • Багц №2 буюу “220/110/35/6 кВ-ын “Эрдэнэт” дэд станцын өргөтгөл, 220 кВ-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажил”-ын гүйцэтгэгчээр “Цагаан хорол” ХХК шалгарч, 2025.02.28-нд гэрээ байгуулан ажиллаж байна. 220 кВ-н ЦДАШ-ын анкер тулгуурын суурийн ажил 100%, Эрдэнэт үйлдвэрийн их зогсолтын /2025.06.28-29 өдрүүдэд/ үеэр Хялганат А, Б-ын ЦДАШ-ийг давуулах ажил хийгдсэн. Эрдэнэт дэд станцын өргөтгөлийн ажлын суурийн ажил	100

							50%-д хүрсэн. Бараа материалын татан авалт 70%-тай. Нийт ажлын явц 60% - Багц-3 буюу “Үйлдвэрлэл технологийн парк”-ийн 110/35/6 кВ-ын 2Х63 МВА чадалтай УТП дэд станц, 110 кВ-ын ЦДАШ-ууд барих ажлын тендерийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас зарлаж 2025.07.01-нд тендерийг нээж үнэлгээг хийсэн бөгөөд 2 компани шаардлага хангаж, “Энх өглөө” ХХК шалгарсан боловч СЯ-нд гомдол гарч дахин зарлахаар болсон байна. Иймд Багц-3 буюу “Үйлдвэрлэл технологийн парк”-ийн 110/35/6 кВ-ын 2Х63 МВА чадалтай УТП дэд станц, 110 кВ-ын ЦДАШ-ууд барих ажлын нээлттэй тендерийг дахин зарлана. - УТП-ын газрыг тойруулан хашаа барих /нийт 16.3 км/ Ажлын явц 93%. - УТП-ийн мэдээллийн технологийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах ажлын тендер 2025.09.17-нд зарласан. - "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-д “Эрдэнэтийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барих арга хэмжээ”-г тусгуулсан. - "Үйлдвэрлэл технологийн паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт"-ыг Засгийн газрын 2024 оны 204 дүгээр тогтоолоор батлуулсан. - Засгийн газрын 2025 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам"-д УТП-ийн газрын тусгуулж хууль тогтоомжтой нийцүүлснээр УТП-ын зориулалтаар газрыг тусгай хэрэгцээнд авах улмаар хууль тогтоомжид заагдсан дэмжлэгийг УТП-ийн удирдлага, нэгж авах урьдач нөхцөл бүрдсэн.	
1.6	Бусад яам, газруудаас боловсруулсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт	-	Санал өгсөн эсэх:	1	1	1	- “Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сангийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын	100

	бичиг, хөтөлбөрийн төсөл, холбогдох асуудалд санал өгнө.		(Тийм:1, Үгүй:0)				төсөлд санал өгч, 2025.01.27-ны 01/229 албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. - “Төрийн өмчийн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2024.01.13-ны 01/60 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. - “Засгийн газрын үндэсний хороо, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, Усны үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал өгч, 2025.02.03-ны 01/301 албан бичгээр БОУАӨЯ-нд хүргүүлсэн. - “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2025.02.24-ний 01/598 дугаар албан бичгээр ЭХЯ-нд хүргүүлсэн. “Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэрэгжилтийн явц, үр дүн болон тулгамдаж буй асуудал”-ын талаарх мэдээллийг боловсруулж, 2025.02.25-ны 01/635 дугаар албан бичгээр ЭЗБХ-нд хүргүүлсэн. - Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2025 онд байгуулах гэрээнд Орхон, Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь, Ховд аймаг болон Нийслэлийн Засаг даргатай аж үйлдвэрийн чиглэлээр хамтран ажиллах асуудлаар санал тусгаж, /2025.01.09/ ТЗУГ-т хүргүүлсэн. - “Үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар газрыг тусгай хэрэгцээнд авах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2025.03.17-ны 01/789 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	
--	--	--	------------------	--	--	--	--	--

							- “Тавантолгой түлш” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2025 оны 18 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2025.03.17-ны өдрийн 01/790 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. - “Эгийн голын усан цахилгаан станцын төслийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2025.03.20-ны өдрийн 01/836 дугаар албан бичгээр БОУАӨЯ-нд хүргүүлсэн. - Төв аймгийн нутагт баригдах Багахангайн 660 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станцын импортоор оруулж ирэх тоног төхөөрөмжид ногдох гаалийн албан татварыг чөлөөлөх, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг сунгах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2025.04.10-ны 01/1068 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. - “Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, дагалдах бусад хуулийн төсөлд санал өгч, 2025.04.16-ны 01/1147 дугаар албан бичгээр ЭХЯ-нд хүргүүлсэн. - “Орхон-Онги, Хэрлэн-Тооно” төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, нэгтгэн зохион байгуулах үүрэг бүхий “Усны төслийн нэгж байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, 2025.04.22-ны 01/1188 дугаар албан бичгээр БОУАӨЯ-нд хүргүүлсэн. - “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай мэдээллийг 2025.04.23-ны өдрийн 01/1227 дугаар албан бичгээр Монгол Улсын Шадар сайдад хүргүүлсэн.	
--	--	--	--	--	--	--	--	--

2.1.	Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх стратеги, хөрөнгө оруулалт, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг холбогдох байгууллагатай хамтран судална.	-	Судалгааны тайлангийн тоо	0	-	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Солонгосын хөгжлийн хүрээлэнтэй хамтран “Монгол улсад аж үйлдвэрийг хөгжүүлэх стратеги /хүнд үйлдвэрт чиглэх нь/” сэдвийн хүрээнд мэдлэг хуваалцах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллав. Тус хөтөлбөрийн хүрээнд Солонгосын жижиг, дунд бизнесийн хүрээлэн (KISME) зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарч дараах 3 дэд сэдвээр холбогдох судалгааг хийж гүйцэтгэн, дунд шатны тайлангийн хэлэлцүүлгийг 2025 оны 3 болон 4 дүгээр саруудад зохион байгуулж, холбогдох талуудын саналыг тусгаж ажилласан. Дэд сэдвүүд: • Монгол Улсад аж үйлдвэрийг хөгжүүлэх стратеги (хүнд үйлдвэрт чиглэх); • Монгол Улсад аж үйлдвэрийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг татах төлөвлөгөө; • Аж үйлдвэрийн хөгжлийн Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл. АҮЭБЯ, АМГТГ, “Эрдэнэс ҮТП” ХХК, “Налайх ҮТП” ХХК, Аж үйлдвэржилтийн үндэсний хорооны Ажлын алба зэрэг байгууллагуудын төлөөлөл бүхий Ажлын хэсэг 2025.06.16-наас 20-ны өдрүүдэд Солонгос улсад зохион байгуулагдсан “Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн стратеги боловсруулах” хамтарсан судалгааны ажлын дунд шатны тайлангийн хэлэлцүүлэгт оролцох, БНСУ-ын аж үйлдвэрийн паркийн удирдлагын төв байгууллага болох KICOX-ийн Jeonnam болон Gyeonggi бүсийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлах зорилгоор албан томилолтоор ажиллав. Энэхүү хэлэлцүүлгийн хүрээнд БНСУ-ын Жижиг, дунд үйлдвэрийн бизнесийн хүрээлэн (KISME), Солонгосын Хөгжлийн Судалгааны Институт (KDI)-ын судлаачид Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, дэлхийн уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн чиг хандлагад нийцүүлэн	100
------	--	---	---------------------------	---	---	---	---	-----

							цаашдын хөгжлийн боломжууд, хүнд үйлдвэрийн салбарын үйлдвэржилтийн стратегийн чиглэлийг тодорхойлох, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд хэрхэн үр ашигтай оролцох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах арга замын талаар судалгаа хийж, санал, зөвлөмж бүхий дунд шатны тайланг боловсруулан танилцуулсан. “Бодлогын зөвлөх үйлчилгээний тайлан”-гийн төслийг 9 дүгээр сард холбогдох талуудад танилцуулж, улмаар англи болон монгол хэлээр орчуулан ирүүлсэнээр тус төсөл амжилттай хэрэгжиж дууссан.	
2.2.	"Тавантолгой" үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэсэн Кокс-химийн цогцолбор барих ажлыг эхлүүлнэ.	15,000	НТЭЗҮ, үндсэн зураг төсөв, ТТҮ-ний ажлын явц, хувиар	10	50	100	-Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах зөвлөлийн 2025.05.16-ны өдрийн хуралдаанаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн барих Кокс-эрчим хүчний үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулсан. -“Эрдэнэс ҮТП” ХХК Тавантолгой ҮТП-ийн хүрээнд Кокс-химийн цогцолбор барих техник, эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшний үнэлгээ, паркийн хөгжлийн төлөвлөгөө, холбогдох судалгааны ажлууд хийгдсэн. -“Эрдэнэс ҮТП” ХХК-д Өмнөговь аймгийн Цогтцэций суманд “Тавантолгой” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх “Тусгай зөвшөөрөл олгох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг 2025.08.18-ны өдрийн 01/2337 дугаар албан бичгээр сайд нарт хүргүүлж санал авсан. “Тусгай зөвшөөрөл олгох тухай” Засгийн газрын тогтоол, холбогдох материалыг 2025.09.18-ны 01/2692 дугаар албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн ба ЗГХ-ны тов	90

							хүлээгдэж байна. Дээрх тогтоолын төсөл батлагдсанаар "Тавантолгой" үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэсэн Кокс-химийн цогцолборыг барих ажлыг эхлүүлэх эрх зүйн орчин бүрдэж, үйл ажиллагаа эрчимжих юм.	
2.3.	Монгол Улсын зэсийн ордуудыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн байршлыг эцэслэн тогтоож, дэд бүтцийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийж хэрэгжүүлнэ.	3,000	Дэд бүтцийн судалгааны ажлын гүйцэтгэл, хувь	0	20	40	Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих асуудлаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Оюутолгой төслийн хөрөнгө оруулагч Рио Тинто компанийн хооронд байгуулах Харилцан ойлголцлын Санамж бичгийн төсөл боловсруулж, газрын даргад хүргүүлсэн. Зэс хайлуулах хоёрдахь үйлдвэрийн байршил тогтоох, дэд бүтцийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулахад шаардлагатай хөрөнгийн задаргаа хийж, холбогдох мэдээллийн хамт ЭЗХЯ-нд 2025.01.30-ны өдөр хүргүүлсэн. ЭЗХЯ-д зэс хайлах үйлдвэр барих болон алт цэвэршүүлэх үйлдвэр барих төслийн өмнө хийгдсэн ажлуудын талаарх танилцуулга, мэдээллийг ЭЗХЯ-д цахимаар хүргүүлж, ЭЗХЯ-ны судалгаа хөгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтнүүдтэй 2025.02.12-ны өдөр уулзалт хийсэн. Эдийн засаг, хөгжлийн яаманд “Дэмжлэг хүсэх тухай” 2025.02.14-ний өдрийн 01/492 албан бичиг хүргүүлсэн. (Судалгаа, ТЭЗҮ боловсруулахад шаардагдах төсөв шийдвэрлүүлэхээр) Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах төслийн талаар хийгдсэн судалгаа, мэдээллийг гаргаж, ҮТБХЗГ-т 2025.02.19-ний өдөр хүргүүлсэн. Польшийн КГХМ компанитай Элчин Сайд Н.Оюундарийн уулзалтын ярианы сэдэвт Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн талаар санал хүргүүлсэн.	100

2.4.	Багануур, Налайх, Багахангай үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барина.	84,355.6	Дэд бүтцийн ажлын гүйцэтгэл, хувь	17	22	30	Эдийн засгийн хөгжлийн зөвлөлтэй хамтран 2025.04.28-ны өдөр цахим уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж “Налайх УТП”, “Багануур УТП”, “Багахангай УТП”-ийн удирдлага, холбогдох албаны хүмүүстэй үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын талаар санал солилцсон Багануур, Налайх, Багахангай үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Багануур УТП, Налайх УТП, Багахангай УТП-ийн удирдлагуудтай хамтран ажиллаж, бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Багануур УТП-ийн хүрээнд өндөр технологид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрчим хүч, хатуу, хийн болон шингэн түлш, аж үйлдвэрийн химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх стратегийн зорилт дэвшүүлж байна. Төслийн хүрээнд 500.5 га газрыг улсын тусгай хэрэгцээнд аваад байна. Паркийн хүрээнд пиролиз, нүүрс-химийн үйлдвэр, хийжүүлэлт, нүүрс-химийн үйлдвэр зэрэг үндсэн үйлдвэрээс гадна устөрөгчийн, аммиакийн, давирхай боловсруулах, кальцийн карбидын зэрэг дагалдах үйлдвэрийн төслийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжүүлэхээр зорьж байна. Төслөөр: жилд 6.7 сая тн нүүрс боловсруулж, 1.2 сая тн хатуу болон шингэн бүтээгдэхүүн, 725 сая м3 байгалийн хий, 2.16 тэрбум. кВт.цаг эрчим хүч үйлдвэрлэх юм. Төслийн эхний шат буюу 2025-2028 онд 841.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэнэ. Налайх УТП-ийн хүрээнд 110/10 кВ-ын дэд станц, ажлын зураг, 2 км сайжруулсан шороон зам, 660 м2 оффисын барилга, гүний худаг, 1.6 км үерийн далан, 4.6 км хатуу хучилттай автозам, цахилгаан дамжуулах агаарын шугам зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн.	100
------	--	----------	--	----	----	----	--	-----

2.5	Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.	1,200.00	Хөгжлийн төлөвлөгөө, техник, ТЭЗҮ, зураг, төсөл батлуулах ажлын явц, хувь	-	20	50	Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах чиглэлээр Төр, хувийн хэвшлийг дэмжих тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажилласан. Эдийн засгийн хөгжлийн зөвлөлтэй хамтран 2025.04.28-ны өдөр хамтарсан уулзалт зохион байгуулж “Налайх ҮТП”, “Багануур ҮТП”, “Багахангай ҮТП”-ийн удирдлага, холбогдох албаны хүмүүстэй үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын талаар санал солилцсон. Багахангай ҮТП-ийн хүрээнд 56 га газрын нэгж талбарыг тодорхойлж баталгаажуулаад байна.	100
2.6.	Аж үйлдвэрийн салбарын түүхий эдийн болон бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнэ, дотоод зах зээлийн экспорт, импорт, үйлдвэрлэлийн статистик мэдээллийг бэлтгэх, дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангана.	-	Мэдээллэ эр хангасан эсэх (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын 2025 оны статистик мэдээлэл (сар, улирал)-д аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын орлого төвлөрүүлэлт, аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, гадаад худалдааны мэдээлэл дүн шинжилгээ хийж удирдлагыг шаардлагатай мэдээллийг хангаж ажилласан.Мөн тухай бүр удирдлагын өгсөн чиг үүргийн дагуу холбогдох судалгаа, мэдээллийг боловсруулж удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан.	100
2.7	Салбарын судалгаа, статистик мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулах, мэдээллийн сан бүрдүүлэх, олон нийтийг нээлттэй, ил тод мэдээллээр хангана.	-	Мэдээл лээр хангасан эсэх (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	“Уул уурхай, газрын тосны салбарын 7 хоног”-ийн мэдээллийг боловсруулж, удирдлагад танилцуулсан. Эдгээр мэдээллийг боловсруулахдаа Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Монголбанк, Монголын хөрөнгийн бирж, Fenwei Energy (www.sxcoal.com), Лондонгийн металлын бирж (www.lme.com), Bloomberg терминал, бусад эх сурвалжаас мэдээлэлд боловсруулалт хийж удирдлагад танилцуулсан.Голлох ашигт малтмалын үнийн мэдээлэл (7 хоног бүрийн 2 өдөр)-ийг холбогдох эх сурвалжийн мэдээлэлд тулгуурлан боловсруулж удирдлагыг	100

							шаардлагатай мэдээллээр тогтмол, бүрэн хангаж ажилласан. Мөн тухай бүр удирдлагын өгсөн чиг үүргийн дагуу холбогдох судалгаа, мэдээллийг боловсруулж удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан.	
Зорилт 3. Инновац шингэсэн тэргүүний техник технологи нэвтрүүлэх, нутагшуулах, дамжуулах, төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгаль орчин, агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр ногоон хөгжлийг дэмжих.								
3.1	Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах зөвлөлийн хуралдааныг зохион байгуулна.	-	Хуралдааныг зохион байгуулсан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн хуралдааныг 2025.03.31, 2025.05.16, 2025.06.13, 2025.08.12-ны өдрүүдэд зохион байгуулсан. Хуралдаанаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотгол, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захиалгаар “Эрдэнэс ҮТП” ХХК-ийн боловсруулсан Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт байгуулах кабель утас үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ, Налайх дүүрэгт байрлах Автомашины бүх төрлийн хаягдал цэнэг хураагуур тээвэрлэх, цуглуулах, түр хадгалах, дахин боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт барих Кокс-эрчим хүчний үйлдвэрийн ТЭЗҮ, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байгуулах “Тавантолгой ҮТП”-ийн хөгжлийн төлөвлөгөө, Сэлэнгэ аймгийн Сайхан, Орхон сумын нутагт байгуулах “Хөтөл ҮТП”-ийн хөгжлийн төлөвлөгөө, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байгуулах “Бор-Өндөр ҮТП”-ийн хөгжлийн төлөвлөгөө, Ховд аймгийн Буянт, Дарви сумын нутагт байгуулах “Эко Ховд” ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг тус тус хэлэлцүүлсэн. Зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийн дагуу хурлын дэг, шинжээч томилох шийдвэр, тэмдэглэл, хуралдаанаас гарсан шийдвэр (дүгнэлт,	100

							зөвлөмж)-ийг Зөвлөлийн даргаар албажуулж ажилласан.	
3.2	"Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр"-ийн төслийг хэрэгжүүлэх	5,018.4	Төслийн хэрэгжилт, хувиар	5	15	30	Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн 2023.12.27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. АҮЭБ сайдын 2025.04.01 ний өдрийн А/72 дугаар тушаалаар “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр”-ийн төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд 2025.04.16-ны өдөр хуралдаж төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - Таван толгой ордын эрчим хүчний болон бусад төрлийн нүүрсийг ашиглах талаар судалгааг эхлүүлж БНХАУ, Япон улсын нүүрс-химийн технологи, CCUS технологийг судалсан. - Эрдэнэс тавантолгойн ХК-ийн Стратеги төлөвлөгөөнд 1.5 тэрбум төгрөгийн төсвийг тусгуулахаар санал хүргүүлсэн. - Туршилтын үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх арга хэмжээний дагуу Дэлхийн устөрөгчийн хэрэглээ эрэлт хэрэгцээ, үйлдвэрлэл, үйлдвэрлэх технологи, хүлэмжийн хийн ялгарлын судалгааны ажлыг эхлүүлсэн. - Хүнд үйлдвэрийн салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн дагуу мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх зорилгоор Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс ҮТП” ХХК, Эрдэнэс тавантолгой ХК, ШУТИС-ийн ХШУС-тай хамтран “Олборлолтоос боловсруулалтруу” Нүүрс-химийн боловсруулалтын Мэргэжлийн ахисан түвшний сургалтыг зохион байгуулсан. Компанийн санхүүгийн нөхцөл байдал, хэрэгжүүлэх төслийн эрэмбээс шалтгаалаад төслийн хэрэгжилт удааширсан тул төслийн нийт гүйцэтгэл 20 % байна.	100

3.3	Засгийн газар хоорондын комиссын Аж үйлдвэрийн хамтын ажиллагааны комиссын үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан хурлын тоо	5	6	-	Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Аж үйлдвэрийн хамтын ажиллагааны асуудлаарх Монгол, Оросын хамтарсан Ажлын хэсгийн хурлын протоколыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж санал авахаар 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Монгол, Оросын хамтарсан Ажлын хэсгийн Монголын талын гишүүдэд хүргүүлсэн.	100
3.4	Уур амьсгалын өөрчлөлт, агаар, орчны бохирдлыг бууруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд салбарын оролцоог хангаж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.	-	Хамтран ажилласан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	0	1	1	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нүүрстөрөгчийн дотоодын арилжаанд оролцох зохицуулалтыг бий болгох, салбар дундын зохицуулалтаар хангах хуулийн төсөлд санал өгч холбогдох байгууллагатай хамтран ажилласан. Арга хэмжээний дагуу БОУАӨЯ-наас зохион байгуулсан “Агаарын чанар. Техникийн шаардлага MNS 4585-2016” болон Агаарын чанарын индексээр агаарын чанарыг үнэлэх, мэдээлэх журам”-ыг шинэчлэх Ажлын хэсгийн хэлэлцүүлэгт оролцож санал боловсруулж 2025 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр хүргүүлсэн. Мөн хүлэмжийн хийн бүртгэл, тооллого, тайлагналын асуудлаар салбарын хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор салбар тус бүрийн хүлэмжийн хийн ялгарлын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлон цаашид шинээр үүсэх тооцооллыг хийх хэрэгцээ шаардлага бий болсон бөгөөд энэ хүрээнд ХБНГУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага GIZ-аас аж үйлдвэр, эрчим хүчний хэрэглээний салбарт дотоодын зөвлөх авч ажиллуулан 2020 оноос өнөөг хүртэлх хүлэмжийн хийн ялгарал болон 2035 он хүртэл хугацаанд шинээр үүсэх тооцоолол, мэдээлэл гаруулахаар “Эрдэнэс ҮТП” ХХК, “Эрдэнэс алт ресурс” ХХК, “Инфинитиспейс” ХХК, “Си Өү Эй Эл” ХХК, “Грийн парк” ХХК-д 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр албан бичиг хүргүүлсэн. Монгол Улс Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)”-ийн зорилтыг ахиулан шинэчлэх дэд ажлын хэсгүүдийн үр дүнг танилцуулах,	100

							хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах, тэсвэртэй, дасан зохицсон нийгэм, эдийн засгийн салбаруудыг буй болгох, иргэд олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх, аж ахуйн нэгж байгууллагын хөгжлийн зорилтыг салбар бүрт уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулах тэргүүлэх чиглэл, арга хэмжээний төслүүдийг танилцуулах уулзалтад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр оролцож ажилласан.	
3.5	Агаар бохирдуулагч үйлдвэр, эх үүсвэрүүдэд экологийн стандарт тогтоож, мөрдүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах.	-	Хамтран ажилласан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	0	1	1	1. “Сайжруулсан шахмал түлш” MNS 5679:2022 стандартыг шинэчлэн боловсруулах ЭХС-ын 2025.01.17-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд MNS 5679:2025 стандартын төлийн боловсруулан Уул уурхай, ашигт малтмалын стандартчиллын техникийн /ТХ20/ хорооны хурлаар хэлэлцэн СХЗГ-ын даргын 2025.10.01-ний өдрийн С/34 тушаалаар батлуулсан. https://estandard.gov.mn/website/masm/standards_details.aspx?code=cf9573c1-4813-4f8d-98ed-4788ea7568e4 2. Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос зохион байгуулсан Агаарын бохирдол-хүн амын эрүүл мэнд (Амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх), Стандарт, хяналт (Зуух, түлшний технологи)”, “Эрх зүйн орчин, бодлого шийдвэрийн хэрэгжилт, санхүүжилт, хариуцлага”, Зуух, түлшний технологийн шийдлүүд” сэдвээр дөрвөн цуврал хэлэлцүүлэг ерөнхий хяналтын сонсголд мэдээллээр хангаж ажилласан. 2025.02.03-04	100
3.8	Хүнд үйлдвэрийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, холбогдох бусад журмыг боловсруулах, батлуулахад холбогдох байгууллагатай хамтран	-	Хамтран ажилласан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	0	1	1	- “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хүрээнд МУУҮА, МҮТПНХ-тай хамтран зохион байгуулж хөдөлмөрийн	100

	ажиллана, нэгдсэн бодлого, удирдамжаар хангана.						аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлд санал хүргүүлсэн. /2025.05.15/ - “MiningWeek & MinePro 2025” - олон улсын уул уурхайн үзэсгэлэн, чуулга арга хэмжээний хүрээнд Нэн түрүүнд ХАБ бага хурлыг зохион байгуулсан. 2025.09.11-13	
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.								
4.1	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлэн, хариуг хүргүүлэх.	-	Шийдвэрлэлтийн хувь	98	100	100	Газрын чиг үүргийн дагуу байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичиг нийт 347ш үүнээс хариу хүргүүлсэн 142ш, хариугүй 197ш, хяналтад 8ш, шийдвэрлэлтийн хувь 94,67 %	100
4.2	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, бодлогын дэмжлэг үзүүлнэ.	-	Хамтран ажилласан эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	1	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд: - “Эрдэнэс ҮТП” ХХК-ийн паркийн нэгжүүдийн техник, эдийн засгийн үнэлгээ, техник, технологийн түвшний үнэлгээ, хөгжлийн төлөвлөгөөтэй танилцаж, “Чиглэл өгөх тухай” 2025.05.26-ны өдрийн 03/1625 дугаар албан бичгийг хүргүүлсэн. - Тавантолгой ҮТП, Дархан ҮТП, Бор-Өндөр ҮТП, Хөтөл ҮТП-ийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, хил заагийг тогтоох асуудлыг холбогдох журмын дагуу шийдвэрлэж өгөх тухай хүсэлтийг 2025.05.20-ны өдрийн 01/1551 дугаар албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн. - “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн удирдлагатай /2025.06.02/ уулзаж, үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон паркийн нэгжийн техник, эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшний үнэлгээ, хөгжлийн төлөвлөгөө, холбогдох бусад асуудлаар санал солилцож, бодлогын дэмжлэг үзүүлсэн. “Эрдэнэс ҮТП” ХХК-д Сэлэнгэ аймгийн Сайхан, Орхон суманд “Хөтөл” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх, Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд “Бор-Өндөр” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл	90

							ажиллагаа эрхлэх, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд “Тавантолгой” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх “Тусгай зөвшөөрөл олгох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг 2025.08.18-ны 01/2337 дугаар албан бичгээр сайд нарт хүргүүлсэн. Тогтоолын төслийг 2025.09.18-ны 01/2692 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. -“Вестерн Холд” ХХК-д “Ховд” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх “Тусгай зөвшөөрөл олгох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг эцэслэн боловсруулж, АҮЭБ-ийн сайдын 2025.09.16-ны 01/2656 дугаар албан бичгээр бүх сайд нарт хүргүүлж санал авсан.	
Зорилт 5. Салбарын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн биелэлтийг тайлагнах								
5.1.	“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан бодлогын зорилтын үр дүнгийн тайланг гаргаж нэгтгүүлнэ.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх талаар тусгагдсан бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцын мэдээллийг нэгтгэж хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн.	100
5.2.	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хариуцсан асуудлаар тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж нэгтгүүлнэ.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссан Аж үйлдвэрийн бодлогын газрын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хугацаанд нь ТЗУГ-т хүргүүлсэн.	100
5.3.	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд хариуцсан асуудлаар тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж нэгтгүүлнэ.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн 2023-2024 оны хүрсэн түвшинг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн биет хэмжээгээр тооцон бэлтгэж, хугацаанд ньТЗУГ-т хүргүүлсэн.	100
5.4.	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хариуцсан асуудлаар тусгагдсан арга хэмжээний тайланг гаргаж нэгтгүүлнэ.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн.	100
5.5.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт хариуцсан асуудлаар тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж нэгтгүүлнэ.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх:	1	1	1	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт аж үйлдвэрийн салбарын бодлогын асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн /ТЗУГ/-т хүргүүлсэн.	100

			(Тийм:1, Үгүй:0)					
5.6.	Төрөөс баримтлах бодлогод хариуцсан асуудлаар тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж нэгтгүүлнэ.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Хариуцсан асуудлаар бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнаж 2025 оны байдлаар гаргаж ТЗУГ-т хүргүүлсэн.	100
5.7.	Ерөнхий сайдын захирамж, албан даалгаврын биелэлтийг нэгтгэж тайлагнана.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Манай газартай холбоотой ерөнхий сайдын 2025 оны 02 албан даалгаврын биелэлтийг ахлах шинжээч болон шинжээчээс мэдээллийг нь авч 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр нэгтгэн ҮТБХЗГ-т хүргүүлсэн.	100
5.8.	Нэгжийн 7 хоног, сарын үйл ажиллагааны тайлан болон АҮЭБ-ийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэж тайлагнана.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Газар, хэлтсийн тайланг 7 хоног, сар, сараар гарган тухай бүр тайлагнаж ТЗУГ-т хүргүүлж, ТНБД-ын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажилласан.	100
5.9.	Яамны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2025 оны хэрэгжилтийг нэгтгэж тайлагнана.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	АҮЭБЯ-ны 2025 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэн хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн.	100
5.10.	Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэж тайлагнана.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	II, IV улирал	Нэгжийн 2025 оны эхний хагас жил болон жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гаргаж 2025.06.12, 2025.12.01-ний-ний өдөр тус тус ТЗУГ-т хүргүүлсэн.	100
5.11.	Сайд, ТНБД-ын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн ажлын хэрэгжилтийг тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	› Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/24 дугаар тушаалаар “Алт цэвэршүүлэх үйлдвэр барих төслийн ТЭЗҮ болон түүнтэй холбоотой баримт бичиг, зэрэг нууцад хамааруулсан мэдээллийг ил болгох үндэслэлийг тодорхойлж, ил болгох баримт бичиг, материалын жагсаалт, үндэслэл бүхий дүгнэлт боловсруулж тагнуулын байгууллагад хүргүүлэх” үүрэг бүхий Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажилласан. Холбогдох асуудлаар Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг	100

							боловсруулж Тагнуулын ерөнхий газарт хүргүүлсэн. › Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Тувааны 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/37 дугаар тушаалаар Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны “Аж үйлдвэр, эрдэс баялаг” сэдэвт салбар хуралдааныг зохион байгуулах Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажилласан. Салбар хуралдааныг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнтэй хамтран Хангайн бүс (2025.04.14-ний өдөр Архангай аймагт), Хойд бүс (2025.04.28-ны өдөр Булган аймагт), Говийн бүс (2025.05.12-ны өдөр Дорноговь аймагт)-ийн амжилттай зохион байгуулсан. › Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай” А/54 дүгээр тушаалаар Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт, зөвлөмж гарган ажиллаж байна. › Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/100 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс баяжуулах үйлдвэрийг хүлээн авах Улсын комиссын бүрэлдэхүүнд ажилласан. /2025.05.09-11/ › Стандарт хэмжил зүйн газраас 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн “Стандартын төсөлд санал авах тухай” албан бичгийн дагуу ISO 10005-2025, MNS ISO 10006- 2017, MNS ISO 10008-2017 стандартуудын төсөлтэй танилцаад холбогдох саналыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 02/1078 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	
--	--	--	--	--	--	--	--	--

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ ҮЙЛДВЭР, ТЕХНОЛОГИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө , АҮЭБЯ-ны 2024-2028 оны стратеги, төлөвлөгөө	Төсөв /сая.төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
Зорилго 1. АХ-4.2.14, 4.2.15, 4.2.16, ШСБ-3.2, МУХТЖҮЧ-4.2.1, 4.2.11, ЗГҮАХ-3.3.1.1, 1.3.5.2, 3.3.1.2, 3.3.1.6, 3.3.1.10, УХЖТ-ийн тэргүүлэх чиглэлийн 1.2.2.4, 1.2.2.5, 1.2.2.6 УХЖТ-ийн 1.4.3, Боловсруулах хүнд үйлдвэрийг нэмэгдүүлнэ.								
Зорилт 1.1. Түүхий эд, бүтээгдэхүүнийг анхан шатнаас гүн боловсруулах хүнд үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.								
1.1.	Арга хэмжээ 1.1.1 Алт цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн тодотгол, зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.	3,000	Ажлын гүйцэтгэл, хувиар	0	5	10	Сүүлийн жилүүдэд алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажилд оролцох сонирхлоо илэрхийлж байсан гадаад, дотоодын 13 компанитай 2025 оны 02 дугаар сараас дахин холбогдож, тус үйлдвэрийн хүчин чадлыг жилд 20 тн алт, 30 тн мөнгө цэвэршүүлэх, өөрийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр барьж байгуулах, тодорхой хугацаанд ажиллуулах	100

						саналыг тавихад уг төслийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт, төлбөрийн нөхцөл, бусад тавигдах шаардлагыг хангахуйц гэж үзэж болох Холбооны бүгд Найрамдах Герман Улсын Koras & EMH Group, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Temarise Gold Refining Limited компаниудын ирүүлсэн 2 саналыг нарийвчлан судлах, техник-технологи, хөрөнгө оруулалт, төлбөрийн нөхцөлийг нарийвчлан тохиролцох, цаашид төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллах боломжийг судлах үүрэг бүхий ажлын хэсэг АҮЭБ-ийн сайдын 2025.09.19-ний өдрийн А/201 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд АҮЭБ-ийн сайдын 2025.11.04-ний өдрийн 01/3145 дугаар албан бичгийг тухайн төслийн холбогдолтой баримт бичгүүдийг нууцаас гарган ил болгох, алт цэвэршүүлэх үйлдвэр барих төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн боломжит хөрөнгө оруулагчдын нийтлэг эрх ашиг сонирхол, тэгш өрсөлдөөнийг хангах, төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг хэрхэн сонгон шалгаруулах талаар чиглэл авахаар ЗГХЭГ-ын дарга С.Бямбацогтод хүргүүлсэн. Улмаар ЗГХЭГ-ын даргын 2025.11.12-ны өдрийн ХЭГ/3192 дугаар албан бичгээр харин ирсэн бөгөөд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн холбогдох заалтын дагуу Алт цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ болон бусад холбогдох баримт бичгийг төрийн болон албаны нууцад хамааруулсан мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ, үндэслэл бүхий дүгнэлтийн хамт	
--	--	--	--	--	--	--	--

							Засгийн газрын хуралдаанаар зохих журмын дагуу хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, төслийн гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгож, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн чиглэл өгсөн тул ажлын хэсэг нь төслийн гүйцэтгэгчийг сонгох олон улсын нээлттэй тендер шалгаруулалтын ажлын даалгаврыг боловсруулаад байна. Төслийн гүйцэтгэгч /хөрөнгө оруулагч/-ийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2026 оны эхний улиралд зарлан сонгон шалгаруулалтыг явуулах нь зүйтэй гэж үзсэн ба тус ажлын даалгаварт тухайн шалгарсан гүйцэтгэгч буюу хөрөнгө оруулагч нь үйлдвэрийн ТЭЗҮ-ээ боловсруулах шаардлагыг тусгасан.	
1.2.	Арга хэмжээ 1.1.2. Дархан-Сэлэнгийн бүс нутагт металл боловсруулах болон металл бүтээгдэхүүний үйлдвэр, дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах.	8,500	Нойтон баяжуулах, хорголжийн үйлдвэрийн төслийн гүйцэтгэл, хувиар	0	5	10	Ган үйлдвэрлэлийн цогцолбор төслийн бэлэн байдлыг хангах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 1.Газрын байршлыг тогтоох, газрыг улсын тусгай хэрэгцээнд авах Дархан-Сэлэнгийн бүс нутагт Ган үйлдвэрлэлийн цогцолбор бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийг хэрэгжүүлж болохуйц 10 байршлыг судлан "Энх тал" зөрлөгийн дэргэдэх талбайд байгуулсан тохиолдолд үүсэх хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор Инженер-Геологийн урьдчилсан судалгааны ажлыг тухайн газарт хийж гүйцэтгээд байна. Энэхүү судалгааны ажлын үр дүнд дээрх газар Ган үйлдвэрлэлийн цогцолбор төслийг	100

						хэрэгжүүлэхэд онцгой хүндрэл бэрхшээл байхгүй болох нь тогтоогдсон ба нийт 997.3 га талбайг эцэслэн сонгосон. Тус газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлын хүрээнд ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025.09.16-ны өдрийн “Санал авах тухай” албан бичгийг Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргалд хүргүүлсэн боловч одоогоор хариу санал ирээгүй байгаа тул Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх ажил хүлээгдэж байна. 2.Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах Эрдэнэс Монгол ХХК нь хөрөнгө оруулагчийн сонгон шалгаруулах хүрээнд Гадаад хэргийн яамаар дамжуулан 2025 оны 03 дугаар сард дэлхийн ган үйлдвэрлэлийн топ 40 компанид хамтран ажиллах санал хүргүүлсэн бөгөөд 2 улсын 11 компани хамтран ажиллах саналаа илэрхийлсэн. Уг санал илэрхийлсэн компаниудын 6-тай нь биечлэн уулзалтыг зохион байгуулж хөрөнгө оруулагч талын санал, нөхцөлийг хүлээн авсан бөгөөд эдгээрээс 3 компани нь Монгол Улсад айлчлан төслийн талбай болон төслийн бэлтгэл ажилтай танилцаж дараагийн шатны уулзалтыг зохион байгуулсан. Цаашид Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлалыг тодорхойлж 2026 оны 1 дүгээр улиралд багтаан хөрөнгө оруулагчийг сонгон гэрээ байгуулахаар төлөвлөж байна. Гангийн цогцолбор байгуулах талаар Засгийн газрын 2025.07.23-ны өдрийн 28 дугаар тогтоол гарч улмаар 2025.08.13-ны өдөр Ерөнхий сайдын 56 дугаар захирамжаар	
--	--	--	--	--	--	--	--

							Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Учралаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	
	Арга хэмжээ 1.1.3. Гангийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ, технологийн түвшний үнэлгээ, дэд бүтцийн зураг төсөл боловсруулах.	15,400	Баримт бичгийн боловсруулалтын явц, хувиар	0	30	90	Гангийн цогцолборын хүчин чадлыг тодорхойлох, технологийг сонгох, ТЭЗҮ-ийн ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024.09.20-ны өдрийн А/121 тушаалаар салбарын мэргэжилтнүүдийг оролцуулан байгуулагдсан ба ажлын хэсэг дүгнэлтээ 2025.04.30-ны өдөр гаргасан. Уг дүгнэлтэд гангийн цогцолборын хүчин чадлыг 1 сая.тн байх нь зөв бөгөөд Домен зуух бүхий технологи ашиглах нь оновчтой талаар тусган, Гангийн цогцолборын ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж бэлдсэн боловч Ерөнхий сайдын 56 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг болоод “Эрдэнэс Монгол” ХХК-аас ирүүлсэн чиглэлийн дагуу ТЭЗҮ-ийг хөрөнгө оруулагч талтай хамтран боловсруулах нь илүү үр дүнтэй гэж үзсэн тул “Эрдэнэс ҮТП” ХХК нь урьдчилсан ТЭЗҮ-ийг дотооддоо боловсруулан, боловсруулалтын явц 70%-ийн гүйцэтгэлтэй байна. 2025 оны 12 дугаар сард багтаан бүрэн дуусгахаар ажиллаж байна.	10
	Арга хэмжээ 1.1.4. Бор-Өндөрийн жоншны баяжмал боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ, технологийн	690.0	Баримт бичгийн боловсруулалтын явц, хувиар	0	30	90	Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт Бор-Өндөрийн жоншны орд, Баргилтын төмрийн хүдрийн орд болон бүс нутгийн бусад ордуудын нөөцөд тулгуурлан байгуулагдах “Бор-Өндөр” ҮТП-ийн газрыг Засгийн газрын 2025.07.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, 762.8 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. Энэ	78

	түвшний үнэлгээ боловсруулах.						хүрээнд БНХАУ-д хийлгэсэн "Жоншны хүдрийн дээжинд хийсэн технологийн туршилт"-ыг үндэслэн Жонш баяжуулах үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг боловсруулж, яамны дэргэдэх ЭБМЗ-ийн 2025.10.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, хүлээн авахаар шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотойгоор БОННУ болон Технологийн түвшний үнэлгээ (ТТҮ) боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Ажлын даалгавар боловсруулж байна.	
	Арга хэмжээ 1.1.5. Бор-Өндөрийн "Хорголжин төмрийн үйлдвэр"-ийн барилга байгууламж барих, тоног төхөөрөмж суурилуулах.	20,700	Ажлын гүйцэтгэл, хувиар	5	10	20	Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт байгуулагдах "Бор-Өндөр" ҮТП-ийн Төмрийн баяжмалыг хорголжлох үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээг боловсруулж 2025 оны 05-р сарын 29-ний өдрийн АҮЭБЯ-ны дэргэдэх холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, дүгнэлт гаргуулж, баталгаажуулсан. Мөн "Бор-Өндөр" ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр АҮЭБЯ-ны дэргэдэх Паркийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулсан. Тус ажлуудын хүрээнд паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулж, АҮЭБ-ийн сайдын 2025.08.18-ны өдрийн 01/2337 дугаар албан бичгээр бүх яамдаас санал авч, холбогдох материалыг зохих журмын дагуу бэлтгэн АҮЭБ-ийн сайдын 2025.09.18-ны өдрийн 01/2692 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. ("Тусгай зөвшөөрөл олгох тухай" Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцэх	100

							асуудал Засгийн газрын 2025 оны 10, 11 дүгээр сарын хуралдааны жагсаалтад орсон боловч тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.)	
	Арга хэмжээ 1.1.6. Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлэх.	1,669,370.79	Барилга, угсралтын ажлын гүйцэтгэл, хувиар	20	30	49	1.Төслийн ЕРС-2, ЕРС-3 багцын барилга угсралтын ажилд шаардлагатай бараа материалыг албан татвараас чөлөөлүүлэх, машин техник, тоног төхөөрөмжийг гаалийн түр гормиоор оруулах, ерөнхий гүйцэтгэгчдийн ажлын гүйцэтгэлийн төлбөрийн санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг тухай бүр Сангийн яаманд хүргүүлж ажиллав. 2025 оны 11 сарын 288-ны өдрийн байдлаар 330 хүсэлтийг хүргүүлсэн байна. Төслийн бүтээн байгуулалтын ажил 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар багц тус бүрийн гүйцэтгэл дараах явцтай байна. Үүнд: ЕРС-01 буюу Иргэний байгууламж-100%, ЕРС-02 буюу Анхдагч технологийн болон дагалдах байгууламжууд – 50,1%, ЕРС-03 буюу Дулааны цахилгаан станц-36,1%, ЕРС-04 буюу Лицензит байгууламжууд – 8,5%, төслийн гүйцэтгэл нийлбэр дүнгээр 34,0%-тай байна. 2.Засгийн газраас 2025.01.22-ны өдөр баталсан ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 31 дүгээр тогтоолын дагуу Анхдагч технологийн болон дагалдах байгууламж (ЕРС 02), Үйлдвэрийн дулааны цахилгаан станц (ЕРС 03), Лицензтэй технологийн байгууламж (ЕРС 04)-ын барилга угсралтын ажлын Ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын Мега Инженеринг & Инфраструктур Лимитед компанийн нийт	100

							589, тос дамжуулах хоолойг барьж байгуулах ажлын Ерөнхий гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит “Норинко Интернэйшнл Кооперэйшн” компанийн 187 БНХАУ-ын ажилчид ажиллаж байна. 2026 онд ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 02-3318 дугаартай албан бичгийг ГБХНХЯ-нд цахимаар хүргүүлсэн.	
	Арга хэмжээ 1.1.7. Дамжуулах хоолойн барилга, угсралтын ажлыг дуусгах.	196,800.25	Тос дамжуулах хоолойн байгууламжийг ашиглалтад оруулна.	80	90	100	Газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр хангах 530 км урттай дамжуулах хоолойн барилга угралтын ажил 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 89,7%-ийн гүцэтгэлтэй, ажлын явц дараах явцтай байна. Үүнд: Шугам хоолойг сувгийн дагуу байрлуулах ажил- 526км, хоолойн гагнуурын ажил - 521км, ухмалын ажил - 520км, хоолой буулгах ажил - 520км, хоолой булах ажил - 519км.	100
	Арга хэмжээ 1.1.8. “Алтанширээт” үйлдвэрийн паркт баригдах Коксын үйлдвэр (600.0 мян.тн)-ийг байгуулах.	52,819.50	Төслийн явц, хувиар	60	70	100	Инфинити спэйс” ХХК (“Болдтөмөр Ерөө гол” ХХК)-ийн хэрэгжүүлж буй “Алтанширээт” үйлдвэрлэл, технологийн парийн хүрээнд 1-1.5 сая тонн хүчин чадалтай төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр болон нүүрс баяжуулах үйлдвэр, 1.0-2.0 сая тонны хүчин чадалтай коксын үйлдвэр байгуулагдахаар төлөвлөж МУ-ын Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан “Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам”-ын дагуу Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, “Алтанширээт” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхэлж буй “Инфинити спейс” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Билэгсайхан нар “Татвар төлөх	65

						хугацаа сунгах, хэсэгчлэн төлүүлэх гурван талт гэрээ"-г 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу паркийн бүтээн байгуулалтад шаардагдах 183 нэр төрлийн 780 тэрбум төгрөгийн өртөг бүхий барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн 39.0 тэрбум төгрөгийн гаалийн татвар, 81.9 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жилээр сунгаж, татвар төлөх хугацааг сунгасан. Паркийн хүрээнд дараах бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгээд байгаа бөгөөд нийт гүйцэтгэл 65%-тай байна. Үүнд: 1. Нүүрс угаах үйлдвэр болон нүүрс ачиж, буулгах талбайг ашиглалтад оруулсан. 2. Бор хөөвөр болон Долоодын говиос гүний ус дамжуулах 103 км урттай шугамын трассын зураглал хийгдсэн. 3. 110/10 кВт-ын 9.4 км цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж байгуулсан. 4. 6.3 мВт-ын цахилгааны дэд станц, 12 км төмөр замын ажлууд дууссан. 5. Коксын үйлдвэрийн газар, шороо, суурийн цутгалтын ажлыг хийж дуусгасан. 6. Коксын үйлдвэрийн хүчин чадал 2.6 мян.тн/жил ба эхний ээлжинд 600 мян.тн/жил хүчин чадалтай үйлдвэрийн зуухны өрлөгийн ажлыг хийж гүйцэтгэж 8 зуухнаас 4 зуухыг угсарч дуусгасан ба үлдэгдэл 4 зуухаа 2025 онд угсарч дуусгах төлөвлөгөөтэй байсан хэдий ч паркийн нэгж үйлдвэрт ашиглах түүхий эдийн асуудал шийдвэрлэгдээгүй тул	
--	--	--	--	--	--	---	--

							үйлдвэрийн туршилт, тохируулгын ажил зогсонги байдалд байна.	
	Арга хэмжээ 1.1.9. Алтанширээт үйлдвэрлэл, технологийн паркт цахилгаан станц барих төслийг эхлүүлэх (20.0 МВт.цаг/тн)	105,639	Төслийн гүйцэтгэл, хувиар	0	50	100	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших “Алтанширээт” үйдвэрлэл, технологийн парк”-ийн хүрээнд баригдах цахилгаан станц барих ажлын суурь ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: 1. 110/10 кВт-ын 9.4 км цахилгаан дамжуулах агаарын шугам 2. 6.3 МВт-ын цахилгааны дэд станц. 3. Нүүрс ачиж, буулгах талбайг ашиглалтад оруулсан. Төслийн гүйцэтгэл-32%	32
	Арга хэмжээ 1.1.10. “Гэрэлт говь” үйлдвэрлэл, технологийн паркт байгуулах Коксын үйлдвэр (500 мян.тн)-ийг үргэлжлүүлэх.	125,968	Төслийн явц, хувиар	30	50	70	"Си Өү Эй Эл" ХХК-ийн хэрэгжүүлж буй Дорноговь аймгийн Хөвсгөл суманд орших “Гэрэлт говь” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд жилд 3 сая тонн хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэр, жилд 600 мянган тонн металлургийн кокс үйлдвэрлэх хүчин чадалтай кокс, эрчим хүчний үйлдвэрүүдийг үе шаттайгаар барьж байгуулахаар төлөвлөж Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан “Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам” болон Засгийн газрын 2024 оны 85 дугаар тогтоолын дагуу Сангийн сайд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, “Си Өү Эй Эл” ХХК хооронд “Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх” 3 талт гэрээг 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу паркийн бүтээн байгуулалтад шаардагдах 1915 нэр төрлийн бараа материалаас 2025 оны 10	82

							дугаар сарын байдлаар 237 нэр төрлийн бараа материалыг 96,686 сая төгрөгөөр импортлон авч 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт бүтээн байгуулалтын гүйцэтгэл 82.0 хувьтай байна. Үүнд: 1. Баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 100%, 2. УТП-ийн төмөр замын барилга угсралт 100% 3. Коксын үйлдвэр, цахилгаан хангамжийн системийн барилга угсралтыг 56% 4. Ус хангамжийн системийн барилга угсралтыг 100%-д хүргэсэн.	
	Арга хэмжээ 1.1.11. Шохой шатаах үйлдвэрийн төсөл эхлүүлэх	61,410	Төслийн явц, хувиар	0	30	80	“Хөтөл” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд баригдах Шохой шатаах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Булжих минерал майнинг" ХХК боловсруулж ЭБМЗ-өөр 2023.06.28-ны өдөр Т/23-09-08 дугаар дүгнэлтээр батлагдсан. "Урьдчилсан халаагчтай эргэх зуух бүхий технологитой жилд 100 мян.тн хүчин чадалтай шохойн үйлдвэр барих" тендерийн гүйцэтгэгчийг 2025.03.13-ны өдөр сонгон шалгаруулсан гүйцэтгэгчээр "Сижен инженерчлэл" ХХК шалгарч, гүйцэтгэлийн ерөнхий төлөвлөгөө, топо зураг боловсруулагдан, архитектур төлөвлөлтийн зургийн даалгавар авах хүсэлтийг холбогдох Хот байгуулалт, барилга сууцжуулалтын яаманд хүргүүлсэн. Мөн үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээг АҮЭБЯ-ны дэргэдэх Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг	50

						бүхий зөвлөлийн 2025.05.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, хүлээн авахаар шийдвэрлэж, “Хөтөл” ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг яамны дэргэдэх Паркийн зөвлөлийн 2025.06.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан. Тус ажлуудын хүрээнд Сэлэнгэ аймгийн Сайхан, Орхон сумын нутаг дэвсгэрт “Хөтөл” ҮТП-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулан, АҮЭБ-ийн сайдын 2025.08.18-ны өдрийн 01/2337 дугаар албан бичгээр бүх яамдаас санал авч нэгтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын материалыг АҮЭБ-ийн сайдын 2025.09.18-ны өдрийн 01/2692 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. байна. Бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхтэй холбоотойгоор төслийн талбайг хашаалах, ажилчдын түр байр барих зэрэг бэлтгэл ажил хийгдсэн. Төслийн инженерингийн нарийвчилсан зураг төслийн 10 багц ажлаас одоогийн байдлаар 8 нь бүрэн дуусаж Сэлэнгэ аймгийн ОБГ болон ЭМГ-р хянуулахаар хүргүүлсэн ба 2 зураг нь 90%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. 2025 онд багтаан зураг төслийг бүрэн экспертизээр баталгаажуулах ба тоног төхөөрөмжийн захиалга хийгдэнэ. Ингэснээр 2026 оны 3-р сараас газар шорооны ажил гүйцэтгэн талбай дээр бүтээн байгуулалт эхлэх төлөвлөгөөтэй байна. Төслийн гүйцэтгэл-50% (“Тусгай зөвшөөрөл олгох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцэх асуудал Засгийн газрын 2025 оны 10,	
--	--	--	--	--	--	--	--

							11 дүгээр сарын хуралдааны жагсаалтад орсон боловч тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.)	
	Арга хэмжээ 1.1.12. Цементийн үйлдвэрийг түшиглэн барилгын материалын үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжийг дэмжих.	-	Дэмжлэг үзүүлсэн байгууллага, тоогоор	0	0	1	“Вестерн Холд” ХХК-ийн хэрэгжүүлж буй Ховд үйлдвэрлэл, технологийн паркт байгуулагдах “Ховд эко цементийн үйлдвэр”-ийн технологийн түвшний үнэлгээг АҮЭБЯ-ны дэргэдэх Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж хүлээн авахаар шийдвэрлэсэн ба Паркийн хөгжлийн төлөвлөгөөг тус яамны холбогдох зөвлөлийн 2025.06.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авахаар шийдвэрлэсэн. Тус ажлын хүрээнд “Вестерн Холд” ХХК-ийн Ховд аймгийн Буянт, Дарви сумын нутаг дэвсгэрт “Ховд” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх “Тусгай зөвшөөрөл олгох” тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулж, АҮЭБ-ийн сайдын 2025.09.16-ны өдрийн 01/2656 дугаар албан бичгээр яамдаас санал авч нэгтгэх ажлыг зохион байгуулсан. Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг эцэслэн тусгаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр ажиллаж байна.	100

	Арга хэмжээ 1.1.13. "Пиролиз, эрчим хүчний үйлдвэр"-ийн төслийг хэрэгжүүлэх.	4,498.38	Төслийн гүйцэтгэл, хувиар	0	5	10	Монгол Улсын Засгийн газрын 2025.03.19-ний өдрийн 139 дугаар тогтоолоор 636.24 га газрыг Багануур ҮТП-ийн зориулалтаар Улсын тусгай хэрэгцээнд авсан. БНХАУ-ын Шинжлэх ухааны академийн Нүүрс-Химийн хүрээлэнд Багануур уурхайн 200 кг төлөөлөх чанар бүхий дээжийг бэлтгэн гаргаж, пиролизийн шинжилгээ хийлгэж урьдчилсан дүгнэлтийг гаргуулж авсан ба ингэснээр ТЭЗҮ, зураг төсөл, ерөнхий төлөвлөлт хийх боломж бүрдсэн. 2025.01.28-ны өдөр Хөх нүүрс төслийн мэргэжлийн ажлын хэсэг байгуулагдсан ба уг ажлын хэсэгт нүүрс-химийн эрдэмтэд, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөллүүд багтсан. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн 2024.12.26-ны өдрийн 107 дугаар тогтоолоор "Эрдэнэс ҮТП" ХХК-ийн харъяа Багануур ҮТП төслийн нэгж (үйлдвэрийн өмнөх захиргаа) байгуулагдсан. Нүүрс-пиролизын үйлдвэрийн бүрэн үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-д хийлгэхээр үйлдвэрүүдийн судалгаа хийгдэж байна. Багануур ҮТП-ийн ерөнхий төлөвлөлт, Нүүрс-Пиролизын үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах "Ажлын даалгавар"-ыг 2025.02.26-ны өдөр боловсруулж, 2025.03.07-ны өдөр ОУ-ын нээлттэй тендер сонгон шалгаруулалтыг зарласан. Нүүрс-Пиролизын үйлдвэрийн ТЭЗҮ, Багануур ҮТП-ийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах тендер сонгон шалгаруулалтын үр дүн 2025.04.08-ны өдөр нээгдсэн бөгөөд гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Сиден Инженеринг" ХХК шалгарсан. Тус компани нь ТЭЗҮ-г эцэслэн боловсруулж 2025 оны 10-р сард хүлээлгэн өгсөн ба одоогоор АҮЭБЯ-нд шинжээч томилуулахаар хүргүүлээд байна. Мөн хагас үйлдвэрийн туршилтын	100
--	--	----------	---------------------------	---	---	----	---	-----

							тендерийг 10-р сард зарласан бөгөөд 2025.11.24-ний өдөр тендерийг нээж гүйцэтгэгчийг шалгаруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ингэснээр 2026 оны 1-р улиралд багтаан хагас үйлдвэрлэлийн туршилт болоод ТЭЗҮ бүрэн баталгаажин дуусаж төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах боломж бүрдэх юм. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар тус төсөлд ажлын хэсэг байгуулсан ба Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Учралаар ахлуулан ажиллаж байна. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025.08.23-ны өдрийн тушаалаар Нүүрс-пиролизын үйлдвэртэй уялдуулан Багануурын уурхайн хүчин чадлыг өргөтгөх хөрөнгө оруулалтын тооцооллыг хийх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.	
Зорилт 1.2. Үйлдвэрлэл, технологийн парк болон боловсруулах үйлдвэрийн төсөл, хөтөлбөр, технологийн түвшний үнэлгээнд үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг зохицуулна.								
14	Арга хэмжээ 1.2.1. Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөлийн хурлыг зохион байгуулах.	-	Зохион байгуулсан хурлын тоо	-	2	2	Технологийн түвшний үнэлгээний зөвлөлийн 3 удаагийн хурлыг 2025.02.11, 2025.03.28, 2025.05.29-ний өдрүүдэд тус тус зохион байгуулж, 6 технологийн түвшний үнэлгээнд ажлын хэсэг байгуулж, 1 байгууллагад Хүнд үйлдвэрлэлийн ТТҮ хийх эрх олгож, 6 төслийн технологийн түвшний үнэлгээг хүлээн авч, дүгнэлт гаргасан. Үүнд: 1.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд баригдах “Молибдений баяжмал боловсруулах үйлдвэр”-ийн технологийн түвшний үнэлгээний тайланд санал, дүгнэлт	100

						гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг ТНБД-ын 2025.02.14-ний өдрийн А/21 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд үнэлгээний тайлан боловсруулагч Хими, химийн технологийн хүрээлэнд 2025.12.14-ний өдөр албаны мэйлээр хүргүүлсэн. 2. “Бор-Өндөр” ҮТП-т байгуулах Төмрийн баяжмалыг хорголжлох үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээний тайланд санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг ТНБД-ын 2025.04.01-ний өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулж, ТТҮ-г хүлээн авсан. 3. “Хөтөл” ҮТП-т байгуулах Шохойн үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээний тайланд санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг ТНБД-ын 2025.04.18-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгуулж, ТТҮ-г хүлээн авсан. 4. “Тавантолгой” ҮТП-т байгуулах Кокс-эрчим хүчний үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээний тайланд санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг ТНБД-ын 2025.04.11-ний өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулж, ТТҮ-г хүлээн авсан. 5. “Ховд” ҮТП-т байгуулах Эко цементийн үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээний тайланд санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг ТНБД-ын 2025.04.08-ны өдрийн А/59 дугаар тушаалаар байгуулж, ТТҮ-г хүлээн авсан. 6. Ачит Ихт ХХК-ийн Катодын зэсийн үйлдвэрийн ТТҮ-г хүлээн авсан. 7. “Эрдэнэт” ҮТП-т байгуулах Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологи (НЛ-	
--	--	--	--	--	--	--	--

							SX/EW)-оор боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээг хүлээн авсан. 8. “Грийн парк” ХХК-ийн хэрэгжүүлж буй Сүхбаатар аймгийн Асгат сумын нутагт орших “Дорнын баялаг” үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэн байгуулах Нүүрснээс дизель түлш үйлдвэрлэх үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээний тайланд санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг ТНБД-ын 2025.10.23-ны өдрийн А/187 дугаар тушаалаар байгуулан төсөл хэрэгжүүлэгч байгуулагад хүргүүлсэн. 9. “Амблаб” ХХК-д Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрхийг ЭЗХ-ийн сайд Н.Учрал, АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням нарын хамтарсан 2025.10.27-ны өдрийн А/50, А/221 дугаар тушаалаар 3 жилийн хугацаатай олгосон.	
15	Арга хэмжээ 1.2.2. Боловсруулах үйлдвэрийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан хурлын тоо	-	0	2	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Аж үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн цахим системд ирсэн хүсэлтийг тухай бүр зөвлөлийн даргад танилцуулан шийдвэрлүүлж, 2025 оны эхний хагас жилд ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдааныг 1 удаа зохион байгуулж 1 асуудал, салбар зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулж 3 асуудал, нийт 4 төслийн ТЭЗҮ-ийг хэлэлцэж, шийдвэрлэсэн. Мөн шинжээч томилохоор хүсэлт ирүүлсэн 3 төслийн ТЭЗҮ-д шинжээч томилсон байна. Яамны бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор АҮЭБ-ийн сайдын 2025.09.10-	100

							ны өдрийн 188 дугаар тушаалаар ЭБМЗ-ийн Аж үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар зөвлөл татан буугдсан.	
Зорилт 1.3. Аж үйлдвэрийн салбарын судалгаа, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.								
16	Арга хэмжээ 1.3.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, цахимжуулах төслийн ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна.	-	Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна. (Тийм:1, Үгүй:0)	0	1	0	Улсын төсвөөр 2025 онд хийж гүйцэтгэх “Үйлдвэрлэл, технологийн паркийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах” Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж, Захиалагчаар батлуулан, ТНБД-ын 2025.04.15-ны өдрийн А/66 дугаар тушаалаар байгуулагдсан тендерийн үнэлгээний хорооны хурлыг 2025.04.23-ны өдөр зохион байгуулж, гарсан шийдвэрийн дагуу зөвлөх үйлчилгээний тендерийн зарыг 2025.04.30-ны өдөр яамны сайт болон Худалдан авах ажиллагааны цахим системээр нийтэлсэн. Мөн үнэлгээний хорооны 2, 3-р хурлыг 2025.05.20, 26-ны өдрүүдэд зохион байгуулан Тендерийг нээж, санал ирүүлсэн “Анд хайрхан” ХХК-ийн материалыг хянан шалгаж баталгаажуулан, хамгийн сайн тендерээр шалгаруулж Гэрээ байгуулах эрхийг ТНБД-ын 2025.05.28-ны өдрийн 02/1667 дугаар албан бичгээр олгосон. Тус ажлын хүрээнд “Анд хайрхан” ХХК-тай 2025.06.03-ны өдөр гэрээний өмнөх хэлцэл хийн, Ажил гүйцэтгэх гэрээг 2025.06.10-ны өдрийн 41 дугаараар байгуулсан. Гэрээний дагуу “Анд хайрхан” ХХК хийж гүйцэтгэсэн эцсийн тайлан хүлээж авахтай холбоотойгоор ТНБД-ын 2025.08.27-ны өдрийн А/146 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг цахим системийн үйл ажиллагаатай танилцаж, ажил хүлээлцэх	100

							акт болон гэрээ дүгнэсэн акт үйлдэн, холбогдох материалын хамт Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст 2025.09.22-ны өдөр хүлээлгэн өгсөн.	
17	Арга хэмжээ 1.3.3. Салбарын инженер, техникийн ажилтан, мэргэжилтнүүдэд зөвлөх болон мэргэшсэн инженер бэлтгэх, давтан сургах сургалтыг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан сургалтын тоо	2	2	0	ШУТИС-ийн Механик инженер, тээврийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, мэргэжлийн холбоодтой хамтран 4 удаагийн сургалт зохион байгуулж нийт Хүнд үйлдвэрийн салбарын 116 инженер, техникийн мэргэжилтнүүдэд зөвлөх, мэргэшсэн инженерийн зэрэг олгосон байна. Үүнд: 1. АҮЭБЯ-ны ТНБД-ын 2025.04.01-ний өдрийн А/49 дүгээр тушаалаар Химийн 26 инженер, техникийн мэргэжилтэнд зөвлөх инженерийн эрхийг 5 жилийн хугацаатай, 7 зөвлөх инженерийн эрхийг 5 жилийн хугацаатай сунгаж, 13 мэргэшсэн инженерийн сунгалтыг 3 жилийн хугацаатай, 17 мэргэшсэн инженерийн зэрэг 3 жилийн хугацаатай олгосон. 2. АҮЭБЯ-ны ТНБД-ын 2025.04.24-ний өдрийн А/77 дугаар тушаалаар Металлурги, механик инженер, металл судлал чиглэлийн 18 инженер, техникийн ажилчдын мэргэшсэн инженерийн эрхийг 3 жилийн хугацаагаар сунгасан. 3. АҮЭБЯ-ны ТНБД-ын 2025.07.07-ны өдрийн Б/100 дугаар тушаалаар Механик, инженер, металл судлалын чиглэлээр 25 инженер, техникийн мэргэжилтэнд мэргэшсэн инженерийн зэргийг 3 жилийн хугацаатай олгосон.	100

Зорилго 2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.

Зорилт 2.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

4.1.	Арга хэмжээ 2.1.2. Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэх.	-	Шийдвэрлэсэн эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	1	License.mn цахим сайтаар газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 2 хүсэлтийг хянан үзэж бүрдүүлбэр дутуу үндэслэлээр хүсэлтийг буцаан шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд шинээр хүсэлт ирүүлээгүй болно.	100
4.2.	Арга хэмжээ 2.1.1. Хүнд үйлдвэрийн салбарын тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, шуурхай шийдвэрлэх.	-	Шийдвэрлэсэн тусгай зөвшөөрлийн тоо	19	10	9	1.Зөвшөөрлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан 2025.02.06-ны өдөр зохион байгуулагдахтай холбогдуулан Хүнд үйлдвэрийн салбараас олгодог тусгай зөвшөөрлийн талаарх танилцуулга бэлтгэсэн. 2.ЗГХЭГ-ын даргын тушаалаар байгуулагдсан Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хүнд үйлдвэрийн салбарт хамаарах тусгай зөвшөөрөл олголттой холбоотой танилцуулга бэлтгэж 2025.05.12-ны өдөр танилцуулсан. 3.Төрөөс хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээг тодорхойлох зорилгоор авч буй судалгааны маягтыг Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх, Машины үйлдвэрлэл эрхлэх, Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх, Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллээр бөглөн	100

						2025.05.13-ны өдөр Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтэст хүргүүлсэн. 4.Тусгай зөвшөөрлийн цахим системээр ирүүлсэн 23 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнд: 4.1. “Эйч Ти Эл” ХХК-д Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.01.10-ны өдрийн А/01 дугаар тушаалаар 5 жилийн хугацаатай олгосон. 4.2. “Мера инженеринг” ХХК-ийн Машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг АҮЭБ-ийн сайдын 2025.01.10-ны өдрийн А/03 дугаар тушаалаар 6 жилийн хугацаагаар сунгасан. 4.3. “Дархангеомаш” ХХК-ийн Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг АҮЭБ-ийн сайдын 2025.01.10-ны өдрийн А/04 дугаар тушаалаар 6 жилийн хугацаагаар сунгасан. 4.4. “Техмонтаж” ХХК-д Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.01.10-ны өдрийн А/02 дугаар тушаалаар 5 жилийн хугацаатай олгосон. 4.5. “Дабат өргөө” ХХК-д Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.01.14-ний өдрийн А/07 дугаар тушаалаар 5 жилийн хугацаатай олгосон.	
--	--	--	--	--	--	---	--

						4.6. “Брос инженеринг” ХХК-д Машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.01.14-ний өдрийн А/08 дугаар тушаалаар 5 жилийн хугацаатай олгосон. 4.7. “Якмобил” ХХК-д Машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.01.14-ний өдрийн А/09 дугаар тушаалаар 5 жилийн хугацаатай олгосон. 4.8. “Мирай рисайклинг” ХХК-д Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.03.10-ны өдрийн А/48 дугаар тушаалаар 5 жилийн хугацаатай олгосон. 4.9. “Бэрх-Өндөр” ХХК-д Машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.04.01-ний өдрийн А/69 дугаар тушаалаар 5 жилийн хугацаатай олгосон. 4.10. “Старлинк бридж интернэйшнл трейд” ХХК-д Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.04.01--ний өдрийн А/70 дугаар тушаалаар 5 жилийн хугацаатай олгосон. 4.11. “Инженер технологийн хөгжил” ХХК-д Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.04.01--ний өдрийн А/71 дугаар тушаалаар 5 жилийн хугацаатай олгосон. 4.12. “Жараахайн булаг” ХХК-ийн Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.05.01-ний	
--	--	--	--	--	--	--	--

						өдрийн А/94 дугаар тушаалаар 3 жилийн хугацаагаар сунгасан. 4.13. “Сэйф рийч” ХХК-ийн Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.05.23-ны өдрийн А/120 дугаар тушаалаар 3 жилийн хугацаагаар сунгасан. 4.14. “Улаанбаатар БҮК” ХК-ийн Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг АҮЭБ-ийн сайдын 2025.05.15-ны өдрийн А/107 дугаартушаалаар 3 жилийн хугацаагаар сунгасан. 4.15. “Зол халиун соронз” ХХК-ийн Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг АҮЭБ-ийн сайдын 2025.06.06-ны өдрийн А/146 дугаар тушаалаар 3 жилийн хугацаагаар сунгасан. 4.16. “Маррий майнинг сервисес” ХХК-ийн Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг АҮЭБ-ийн сайдын 2025.06.06-ны өдрийн А/146 дугаар тушаалаар 3 жилийн хугацаагаар сунгасан. 4.17. “Ораметалл” ХХК-ийн Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг АҮЭБ-ийн сайдын 2025.06.10-ны өдрийн А/151 дугаар тушаалаар 6 жилийн хугацаагаар сунгасан. 4.18. “Оч гал баян” ХХК-ийн Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг АҮЭБ-ийн сайдын	
--	--	--	--	--	--	---	--

						2025.06.10-ны өдрийн А/152 дугаар тушаалаар 5 жилийн хугацаагаар сунгасан. 4.19. “Электрокем Монгол” ХХК-ийн Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг АҮЭБ-ийн сайдын 2025.09.19-ний өдрийн А/199 дугаар тушаалаар 3 жилийн хугацаагаар сунгасан. 4.20. “Үлэмж хүдэр” ХХК-ийн Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг АҮЭБ-ийн сайдын 2025.09.19-ний өдрийн А/200 дугаар тушаалаар 5 жилийн хугацаагаар сунгасан. 4.21. “Талст урлан” ХХК-ийн Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг ТНБД-ын 2025.09.19-ний өдрийн шийдвэрээр 5 жилийн хугацаагаар сунгасан. 4.22. “Эс энд эм сольюшн” ХХК-ийн Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг АҮЭБ-ийн сайдын 2025.09.29-ний өдрийн А/210 дугаар тушаалаар 3 жилийн хугацаагаар сунгасан. 4.23. “Эрдэм гоёл” ХХК-ийн Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг ТНБД-ын 2025.09.26-ны өдрийн шийдвэрээр 5 жилийн хугацаагаар сунгасан. 4.24. Зөвшөөрлийн цахим системд 2025.12.01-ний өдрийн байдлаар “Батмонгол хийц” ХХК, “Наран төмөр” ХХК, “Талын металл нунтаг” ХХК, “Мөнхгэрэлт оргил” ХХК, “Хантуул трэйд” ХХК, “Хур түмэндэмбэрэл” ХХК, “Ресурс-	
--	--	--	--	--	--	---	--

							Альянс” ХХК зэрэг 7 ААНБ-ийн тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгах хүсэлтүүд АҮЭБ-ийн сайдад танилцуулагдаж байна. 5. Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 01/2333 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Зөвшөөрлийн цахим системд өөрчлөлт, шинэчлэл хийж, хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийн олголтыг 10 хоногт, сунгалтыг 5 хоногт багтаан шийдвэрлэх тохиргоог хийсэн. Үүнтэй уялдуулан өмнө тушаалаар шийдвэрлэж байсан зохицуулалтыг өөрчлөн, ТЗУГ-ын Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтэс болон ЭЗХЯ-ны Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр тушаалгүй шийдвэрлэдэг тохиргоог хийсэн. 6. Аж үйлдвэрийн салбарт хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг, хууль, журамд заасны дагуу тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгож байгаа бүртгэлийн жагсаалт зэргийг холбогдох маягтын дагуу гарган ТЗУГ-ын Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтэст 2025.09.10-ны өдөр дотоод сүлжээгээр хүргүүлсэн.	
4.3.	Арга хэмжээ 2.1.3. Салбарын бодлого, төлөвлөлт, хууль, тогтоомж, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохицуулах.	-	Хүрүүлсэн эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	1. МУ-ын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт оруулах саналыг гаргаж Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2025.04.25-ны өдөр хүргүүлсэн. 2.Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд Ган үйлдвэрлэлийн цогцолбор, Алт цэвэршүүлэх үйлдвэр, Газрын тос	100

						боловсруулах үйлдвэр, Нүүрс-химийн цогцолбор төслүүдийг тусган батлуулсан. 3.Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт болон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан ТЗУГ-ын ХХ-т 2025.02.12-ны өдөр хүргүүлсэн. 4.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан Хүнд үйлдвэрт хамаарах ”Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх”, “Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх” тусгай зөвшөөрөлтэй холбогдох харилцааг зохицуулах хүрээнд Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан 2025.06.06-ны өдөр ТЗУГ-ын ХХ-т хүргүүлсэн. 5.Эрдэм шинжилгээ, судалгааны ажил 2026 оны төсвийн хязгаарын төсөлд 4 судалгаа хийх санал боловсруулан 2025.06.05-ны өдөр АҮБГ-т цахимаар хүргүүлсэн. 6. “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийг 2025-2028 онд хэрэгжүүлэх хамтран ажиллах төлөвлөгөөний төсөлд санал боловсруулан, ахлах шинжээч Д.Дамбад 2025.09.01-ний өдөр дотоод сүлжээгээр хүргүүлсэн.		
4.4.	Арга хэмжээ 2.1.4. Бусад яам, газруудаас боловсруулсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төсөл, бодлогын баримт бичиг,	-	Санал өгсөн эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	1.MNS ISO 9202-1:2025, Үнэт эдлэл ба үнэт металл. Үнэт металлын хайлшны сорьц”, “MNS ISO 11596:2025, Үнэт эдлэл ба үнэт металл. Үнэт металл болон үнэт металлын хайлшнаас дээж авах арга”, “MNS ISO 15093:2025, Үнэт эдлэл, үнэт металл. Өндөр чанарын алт,	100

	хөтөлбөрийн төсөл холбогдох асуудалд санал боловсруулж, хүргүүлэх.					цагаан алт, паладийг тодорхойлох нь. ICP-OES-ийг ашиглах өөр өөр арга” зэрэг стандартын төслүүдэд санал боловсруулж ТНБД-ын 2025.03.12-ны өдрийн 02/743 дугаар албан бичгээр СХЗГ-т хүргүүлсэн. 2.Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Ноот бичгийн болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд санал боловсруулан Гадаад харилцааны сайдад 2025.04.08-ны өдрийн 01/1043 дугаар албан бичиг хүргүүлсэн. 3.Аж үйлдвэрийн салбарын Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, олон улсын худалдааны тарифын нөхцөл байдлаас шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой хамаарах чухал гэсэн товч мэдээллийг гарган Геологи, цөмийн энергийн хэлтсийн дарга Х.Санчигдоржид 2025.04.11-ний өдөр хүргүүлсэн. 4. “МУ-ыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбараас тусгах саналыг холбогдох маягтын дагуу боловсруулж цахимаар 2025.08.29-ний өдөр хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд ЭЗХЯ-ны Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн зөвлөх Г.Цэрэнжаргалтай 2025.08.29-ний өдөр уулзаж, санал солилцсон. 5.Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл болон үйлдвэрлэл, технологийн	
--	--	--	--	--	--	--	--

						паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт хийх санал боловсруулан 2025.09.26-ны өдөр ТЗУГ-ын ХХ-т хүргүүлсэн. 6. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 64 дүгээр захирамжаар Авлигатай тэмцэх, авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх хүрээнд Аж үйлдвэрийн салбарт мөрдөгдөж буй дүрэм, журам, заавар, захиргааны хэм хэмжээний акт, зөвшөөрөл болон төрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардагддаг дүгнэлт зэрэг мэдээллийг холбогдох маягтын дагуу бөглөн ТЗУГ-ын ХХ-т 2025.09.03-ны өдөр хүргүүлсэн. 7. Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор тусгай зөвшөөрлийг багасгах асуудалд өөрийн хариуцсан чиглэлээр санал боловсруулж, нэгтгэлд 2025.09.09-ний өдөр хүргүүлсэн. 8. Яамны албан хэрэг хөтлөлтийн журам шинэчлэн боловсруулахтай холбоотойгоор санал боловсруулж, Хөтлөх хэргийн жагсаалтыг гарган 2025.09.23-ны өдөр ТЗУГ-т дотоод сүлжээгээр хүргүүлсэн. 10. Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх, Машины үйлдвэрлэл эрхлэх, Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлүүдийн	
--	--	--	--	--	--	---	--

							тоон болон ерөнхий мэдээллийг 2025.10.20-ны өдөр гаргасан. 11. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтээс хэрэгжсэн болон хугацаа нь дууссан шийдвэрүүдийг хяналтаас хасах саналыг боловсруулан, ХШҮДАГ-т 2025.11.07-ны өдөр хүргүүлсэн.	
	Арга хэмжээ 2.1.5. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлэх.	-	Шийдвэрлэлтийн хувь	-	97	97	Нийт 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл албан бичиг-318, өргөдөл, хүсэлт-1 ирсэн байна. Шийдвэрлэсэн албан бичиг - 213, Хяналтанд-12, Хариугүй албан бичиг-94, Албан бичгийн шийдвэрлэлт-95% байна.	98
Зорилт 2.2. Салбарын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн биелэлтийг тайлагнах								
5.1.	Арга хэмжээ 2.2.1. Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь тайлагнасан.	100
5.2.	Арга хэмжээ 2.2.2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Монгол Улсын ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг сар бүр хугацаанд нь журмын дагуу тайлагнасан.	100
5.3.	Арга хэмжээ 2.2.3. Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг улирал бүр гаргаж нэгтгэлд хүргүүлж байна.	100

5.4.	Арга хэмжээ 2.2.4. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Тайлангийн хугацаанд хариуцсан асуудлаар хөтөлбөрт тусгагдаж батдлагдсан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргаж ТЗУГ-т хүргүүлж ажиллав.	100
5.5.	Арга хэмжээ 2.2.5. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Тайлангийн хугацаанд хариуцсан асуудлаар хөтөлбөрт тусгагдаж батдлагдсан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргаж ТЗУГ-т хүргүүлж ажиллав.	100
5.6.	Арга хэмжээ 2.2.6. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Тайлангийн хугацаанд хариуцсан асуудлаар хөтөлбөрт тусгагдаж батдлагдсан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргаж ТЗУГ-т хүргүүлж ажиллав.	100
5.7.	Арга хэмжээ 2.2.7. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	МУ-ын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан Газрын тос боловсруулах үйлдвэр, Ган үйлдвэрлэлийн цогцолбор, “Алтанширээт” ҮТП, “Гэрэлт говь” ҮТП зэрэг төслүүдийн хэрэгжилтийг 2025.04.23-ны гаргасан. 2.Алсын хараа 2050 МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг болон Хууль, тогтоомж тогтоол шийдвэрт тусгагдсан Аж үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны 8 сарын байдлаар нэгтгэн гаргаж Эйбл системийн Ажил хэрэг цэсэнд 2025.09.16,17-ны өдрүүдэд байршуулсан.	100

							3. МУ-ын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Аж үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нэмэлтээр гарган дотоод сүлжээний Ажил хэрэг цэсэнд 2025.10.02-ны өдөр байршуулсан.Тус ажлын хүрээнд Эрдэнэт үйлдвэрийн түшиглэн байгуулах ҮТП, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл, Алтанширээт ҮТП, Гэрэлт говь ҮТП, Алт цэвэршүүлэх үйлдвэрийн төсөлтэй холбоотой хэрэгжилтийн, нотлох баримтыг 2025.10.08-ны өдөр ХШҮДАГ-т файлаар хүргүүлсэн.	
5.8.	Арга хэмжээ 2.2.8. Нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулна.	-	Хугацаанд нь боловсруулсан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	1	Яамны 4 жилийн стратеги болон Нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, удирдлагад танилцуулж 2025.01.10-ны өдөр ТЗУГ-т хүргүүлсэн.	100
5.9.	Арга хэмжээ 2.2.9. Нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	I-IV улирал	Нэгжийн болон Төрийн жинхэнэ албан хаагчийн эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан гарган, удирдлагад танилцуулж 2024.06.12-ны өдөр ТЗУГ-т хүргүүлсэн. Нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг 2025.12.01-ний өдөр гарган, ТЗУГ-т хүргүүлсэн.	100
5.11.	Арга хэмжээ 2.2.11. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх:	1	1	-	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт тусгагдсан Алт цэвэршүүлэх үйлдвэр, Ган үйлдвэрлэлийн цогцолбор, Газрын тос боловсруулах үйлдвэр, Алтанширээт ҮТП зэрэг төслүүдийн	100

			(Тийм:1, Үгүй:0)				хэрэгжилтийг тухай бүр шинэчлэн гаргаж ТЗУГ-т хүргүүлсэн.	
5.12	Арга хэмжээ 2.2.12. Нэгжийн 7 хоног, сарын үйл ажиллагааны тайлан болон УУХҮ-ийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	II, IV улирал	Нэгжийн 7 хоног, сар, шуурхайн үүрэг даалгаварын хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь гарган тайлагнасан.	100
5.13	Сайд, ТНБД-ын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн ажлын хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах.	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх: (Тийм:1, Үгүй:0)	1	1	I-IV улирал	- Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 244 дүгээр тушаалаар БНЭУ-ын ЭкСим банкны нэмэлт санхүүжилтийн зээлийн хэлэлцээ хийх Ажлын хэсэгт гишүүнээр, -УИХ-ын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 1-р тогтоолоор байгуулагдсан газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн үйл ажиллагааг шалгах Ажлын хэсэгт гишүүнээр, -АҮЭБС-ын 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/85 дугаар тушаалаар байгуулагдсан гамшгаас хамгаалах улсын албаны бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн н/б/д-аар, -ОБЕГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/56 дугаар байгуулагдсан Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний тайланд дүгнэлт гаргах шинжээчийн багийн гишүүнээр тус тус ажиллав.	100

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх ажил	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
1	Арга хэмжээ №1. Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд оролцож, зохион байгуулна.	Сургалт, семинар, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулсан, оролцсон байна.	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Төрийн албаны зөвлөл, бусад байгууллагаас зохион байгуулж байгаа сургалт, семинар, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд оролцож, зохион байгуулсан.	I-IV улирал
2	Арга хэмжээ №2. Өөрийн мэдлэг, чадвараа хөгжүүлж, мэргэшил, ур чадвараа дээшлүүлнэ.	Сургалтанд хамрагдсан байна.	Өөрийн мэдлэг, чадвараа хөгжүүлж, мэргэшил, ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдсан.	I-IV улирал

ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛСЭН:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА...../ Б.ДАШПҮРЭВ/
(албан тушаал) (гарын үсэг) (Огноо)

ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛСЭН:

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, Дотоод аудитын газрын дарга..... /Ц.ӨНӨРНАСАН /
(албан тушаал) (гарын үсэг) (Огноо)

ТАЙЛАГНАСАН:

Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга..... / М.МЭНДБАЯР/
(албан тушаал) (гарын үсэг) (Огноо)